



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/71

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйл, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны А/07 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хангай-Багахангай хоорондын замын 508-р км-ийн гармын жижүүрийн байр, Паш хаалтаар тоноглох холбоо, гадна цахилгаан, сирп тоног төхөөрөмж суурилуулах угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны

дарга: Д.Хүрэлбаатар

Гишүүд: Б.Гэрэлмаа

Л.Бадрах

Ц.Бор

Нарийн бичиг:

Д.Амгалан

Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын захирал Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ын инженер 1 дүгээр хорооны иргэн

Худалдан авах ажиллагааны албаны Ахлах мэргэжилтэн

2. Хууль, тогтоомжийн дагуу ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Үнэлгээний хороо (Д.Хүрэлбаатар)-нд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД